Журмын 3б хавсралт

# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

**2025 оны 10 дугаар сарын 30** **Гучин-Ус сум**

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага, хэрэгжих хугацаа | Нийт хөрөнгийн эмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2-3 | 4-5 | 6-7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| **НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | |
| **1.2.ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ДЭД ТӨВ** | | | | | | | | | |
| **1.2.5.Гучин-Ус төвтэй Богд, Төгрөг, Баруунбаян-Улаан сумдыг хамарсан "Говийн бүс"-ийг Бага Илэнх-Шивээхүрэн чиглэлийн Улсын эдийн засгийн босоо коридорыг түшиглэн хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 1 | 1.2.5.1. Улсын чанартай А0302 авто замаас Гучин-Ус, Богд сум хүртэлх 172км авто замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж, ажлыг эхлүүлнэ. | ЗТЯ<br>2025-2028 | 345,4162.00<br>Улсын төсөв | ТЭЗҮ, зураг төслийг боловсруу лалт (гүйцэтгэл ийн хувь)<br>- | 100 | - | - | Гучин-Ус, Богд сум хүртэлх 172км авто замын ТЭЗҮ, зураг төслийг хийж байгаа "Классик Роуд" ХХК-д сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний авто замын төлөвлөлтийн мэдээллийг хүргүүлж, хамтран ажилласан. | 100 |
| 2 | 1.2.5.3. Уламжлалт мал аж ахуйн гаралтай (тэмээний ноос, ямааны ноолуур) түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх аж ахуйг дэмжинэ. | ХХААГ<br>2025-2028 | 3,825.00<br>Хөнгөлөлттэй зээл,<br>хувийн хэвшил | Дэмжлэгт хамрагдсан ААН<br>22 | 15 | 1,275.0 | 0.2 | Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих зорилгоор 2023 онд хоршоо хөгжүүлэх сангаас гар урлал, модон эдлэл чиглэлээр зээл авсан 4 иргэн үйл ажиллагаагаа тогтмол явуулж, зүү ороох урлалаар хөөргний даалин, бүс, үсний уут, монгол гутлын хээ, малгай зэрэг бүтээгдэхүүнийг урлаж сум, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцон "Гар урлалын шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч"-ээр шалгарч үндэсний уламжлалт уран хатгамалыг сурталчилан таниулж, түгээн дэлгэрүүлж байна. Малын хялгас, ноос хөөврөөр гэрийн оосор, бүслүүр, ширмэл, олом, жирэм, шагайны уут, | 100 |

Журмын 3б хавсралт

# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 10 дугаар сарын 31 Гучин-Ус сум

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага, хэрэгжих хугацаа | Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2- 3 | 4-5 | 6-7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | |
| **2.1.ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ** | | | | | | | | | |
| **2.1.1.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Политехник коллежийн сурагчдын сурлагын амжилт, гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг дээшлүүлнэ.** | | | | | | | | | |
| 1 | 2.1.1.1.Хүүхдийн хөгжлийн онцлог, суралцах чадамжид суурилсан уян хатан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг хэрэгжүүлнэ. | БГ 2025-2028 | - | шинээр | 2 сургууль, 2 цэцэрлэг | - | | Цэцэрлэг нь сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн сургалтад 5 багш хамрагдан хөтөлбөрийн дагуу сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж, аймгийн Боловсролын газраас томилогдсон Дэмжлэгийн багтай хамтран хөтөлбөр, төлөвлөгөө, төлөвлөлтийг сайжруулан ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургууль нь байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд нийт 23 багш, 12 судлагдахуунаар шалгалтад орж давхардсан тоогоор 428 суралцагч шалгалт өгсөн байна. Эцэг эхийн санал асуулгад 285 эцэг эх хамрагдахаас 272 буюу 95,4 хувь, сурагч байгууллага үнэлэх асуулгад 35 сурагч хамрагдахаас 34 сурагч буюу 97.1 хувь хамруулж, байгууллагын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | менежмент удирдлагын манлайлал 91,6 хувь, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн 65,8 хувь, хүүхдийн хөгжил хамгаалал 93,9 хувь, хүний нөөцийн бодлого багш ажилтны тасралтгүй хөгжил 89,74 хувь, сургалтын орчин бүрдүүлэлт 91,4 хувь, эцэг эх олон нийтийн түншлэл оролцоо 90,45 хувь үнэлэгдэж, нийт үнэлгээ IV индекс, стандарт гүйцэтгэлийн хувь өмнөх жилээс 0,6 хувиар өссөн. | |
| 2 | 2.1.1.2. Ерөнхий боловсролын сургуулийн 3-5 дугаар ангид англи хэлний Pearson, математикийн Eduten хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцагсдад кодчилол, роботик болон хиймэл оюуны ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ. | БГ<br>2025-2028 | - | хэрэгжилтийн хувь Pearson-80 Eduten-85 | Pearson-90 Eduten-90 | - | - | 2024-2025 оны хичээлийн жилд Eduten хөтөлбөрт бага ангийн 171 сурагч, Pearson хөтөлбөрт 81 сурагч тус тус хамрагдаж, холбогдох гэрээг цахимаар байгуулан төлбөрийн Боловсролын ерөнхий газарт шилжүүлсэн. Pearson хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ 67 хувь, Eduten хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээний дундаж 63,2 хувь үнэлүүлсэн. 2025-2026 оны хичээлийн жилд Eduten 1-6 дугаар ангийн 186 сурагч, Pearson хөтөлбөрийн 3-8 дугаар ангийн 155 сурагч хичээллэж, оношлох шалгалтын гүйцэтгэлийн дундаж 60.5 хувиар шалгагдсан. Eduten хөтөлбөрийн бага ангийн стандарт 65 хувь, дунд ангийн стандарт 60 хувь, Pearson хөтөлбөрийн бага ангийн стандарт 55 хувь, дунд ангийн стандарт 62 хувь байна. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 2.1.1.3. Анги нийтийн аймгийн олимпиад зохион байгуулж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг сайжруулан, анги хамт олны сурлагын амжилтыг үнэлж, дүгнэнэ. | БГ 2025-2028 | 20.00 Улсын төсөв | Гүйцэтгэлийн хувь 45 | 50 | - | - | Анги нийтийн массын олимпиадын 1 дүгээр шатыг сумандаа 6 төрлийн судлагдахуунаар давхардсан тоогоор 22 анги бүлэг оролцож стандарт гүйцэтгэлийн дундаж 47,6 хувь, 2 дугаар шатыг судлагдахуун тус бүрд шалгарсан анги бүлгүүд оролцож, гүйцэтгэлийн дундаж 39,1 хувьтай үнэлэгдсэн. Аймгийн төрөлжсөн олимпиадын шагналт байруудад эрэгтэй дизайн технологийн багш V байр, мэдээлэл технологийн сурагч бүтээлийн төрөлд III байрыг тус тус эзэлсэн. | 50 |
| 4 | 2.1.1.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, удирдлага болон багш солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | БГ 2025-2028 | Улсын Болон орон нутгийн төсөв, бусад | Зөвлөн тусалсан байгууллага 14 Хөтөлбөр Хэрэгжүүлсэн 6сургууль, 18цэцэрлэг 60 багш, | 20 12 сургууль, 24 цэцэрлэг, 80 багш | - | - | "Багшийн хөгжил" хөтөлбөрийн хүрээнд "Говь-Эрдэнэ" бүсийн сайн туршлага түгээх, харилцан суралцах, хамтран хөгжих үйл ажиллагааг 5 чиглэлээр зохион байгуулж, 5 сургуулийн 136 багш, ажилтан оролцсон. Үүнд залуу багш нарын манлайлал, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт "Бүтээлийн үзэсгэлэн", заах аргач, тэргүүлэх зэрэгтэй багш нарын "Тэргүүн туршлагаа түгээх" брошур гарын авлага, танилцуулга, сургууль бүрийн онцлог үйл ажиллагаа, сайн туршлага түгээх "Видео мэдээлэл", суралцахуйн зорилтоо шинжлэх, хэлэлцүүлэгт хичээл, 5 төрөлт спорт тэмцээнийги зохион байгуулсан. Багш солилцоо хөтөлбөрийн хүрээнд Наран бүрэн дунд сургуультай хамтран бага ангийн сургалтын менежер, гадаад хэлний багш, мэдээлэл технологи, математикийн багш нарыг хамруулахаар төлөвлөгөөнд оруулж, бэлтгэл ажлыг хангаж байна. | 100 |
| **2.1.2.Боловсролын байгууллагын барилга, байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг багасгана.** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 2.1.2.5. Ерөнхий боловсролын сургуулийг гадна биеийн тамирын талбайтай болгож, ерөнхий боловсролын сургууль, Политехник коллеж, цэцэрлэг, дотуур байр, спорт заалуудад их засвар хийнэ. | БГ<br><br>2025-2028 | 18,000.00<br><br>Улсын төсөв | гүйцэтгэлийн дундаж хувь<br><br>17 | 14 | 50.0 | 49.9 | Ерөнхий боловсролын сургуулийн гадна биеийн тамирын талбайг орон нутгийн хөгжлийн сангийн 49.9 сая төгрөгөөр санхүүжүүлж, бүрэн тохижуулсан. | 100 |
| 6 | 2.1.2.6. Ерөнхий боловсролын сургууль бүрийг дижитал технологид суурилсан "Ухаалаг анги"-тай болгож, сургууль, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж, хатуу зөөлөн эдлэл, кабинетын тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэн, камерын шинэчлэлийг хийнэ. | БГ<br><br>2025-2028 | 1,090.00<br><br>Улс, орон нутгийн төсөв | Ухаалаг ангитай байгууллагын тоо 5<br><br>Хатуу зөөлөн эдлэл, камерын шинэчлэл байгууллагын тоо<br>20 | 10<br><br>10 | 250.00 | 16.2 | Дэзэрт олон улсын байгууллагын хандиваар 14 ширхэг chrombook, нөхөн хангалтын зардалыг 16.2 сая төгрөгөөр 75 инчийн 2 зурагт, 12 таблетыг цахим дэлгүүрээс худалдан авч цахим ангийн тоог нэгээр нэмэгдүүлж, 2 цахим танхимтай болсон. | 100 |
| **2.1.3.Боловсролын бүх шатанд хүүхдийн хөгжил, хамгааллын орчинг сайжруулж, хүүхдийн сурч, хөгжих тэгш эрхийг хангана.** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | 2.1.3.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт "Сүү хөтөлбөрт" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | БГ 2025-2028 | 11,694.00 Улсын болон орон нутгийн төсөв, бусад | Хамрагдсан хүүхдийн тоо | 2426 /6-р анги/ | 5.4 | 7.2 | "Сүү хөтөлбөрт" арга хэмжээний хүрээнд 7 хоногийн 4 өдөрт цэцэрлэгийн 87 хүүхдийг 100 хувь, Ерөнхий боловсролын сургуулийн 3-5 дугаар сард 6 дугаар ангид эцэг эхийн санхүүжилтээр хэрэгжүүлж эхлэн 2025-2026 оны хичээлийн жилд сурагчдын үдийн хоолны цэсэнд долоо хоногт 2 удаа тогтмол сүү өгч хэвшсэн. | 70 |
| 8 | 2.1.3.2. Бага насны (0-5 нас) хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж, 1-2 насны хүүхдийн яслийн үйлчилгээний хувилбарыг бий болгоно. | БГ 2025-2028 | | эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулсан хүүхдийн хувь 70<br>хөтөлбөрийн хэрэгжилт шинэ | 75<br>90 | - | | Сумын Эрүүл мэндийн төвөөс Цэцэрлэгийн хүүхдүүдэд Улаанбурхан, салхин цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг багш нар, салхин цэцэг илрүүлэх үзлэгийг хийж, томуугийн вакцинд 95 хувь хамруулсан. Шүд зөв угаах аяны хүрээнд шүдний өвчлөлийг илрүүлж, 46 хувьд эмчилгээ хийж, эрүүлжүүлж, шүд угаах сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| 9 | 2.1.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурч, хөгжихөд шаардлагатай тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангаж, багшлах боловсон хүчнийг мэргэшүүлэн, нийгэм, хамт олонд нь түшиглэн сэргээн засах үйлчилгээг үзүүлнэ. | БГ 2025-2028 | 38.00 Улс, орон нутгийн төсөв | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамран сургалтын хувь 84 | 86 | - | 0.2 | Цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй 1 суралцагч хамрагдаж, Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 7 суралцагчаас 3 суралцагч ганцаарчилсан хөтөлбөрөөр суралцаж, багшийн ХПЗ-аас тохируулгат хэрэглэгдэхүүнийг авч ашиглаж хэвшсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж, Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан урлагийн наадамд ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллэж буй 1 сурагчийг гоцлол бүжгийн төрлөөр бэлтгэн, унаа болон оролцооны | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | мөнгөөр дэмжин оролцуулж, тусгай байрт шалгарсан. | |
| 10 | 2.1.3.4. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, хувилбарт сургалтад хамруулна. | БГ<br>2025-2028 | Улсын төсөв | Таблеттай багш хөтөлбөр хэрэгжилт хувь<br><br>шинэ | 80 | - | 5.0 | Хамран сургалтыг нэмэгдүүлэх, малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах зорилгоор Аргалант 3 дугаар багийн төвийг түшиглэн нүүдлийн гэр цэцэрлэгийг 21 хоногийн хугацаатай хувилбарт сургалтыг ажиллуулж, эцэг, эх, хүүхдүүдэд зориулан 2 уралдаан тэмцээн зохион байгуулсан. | 100 |
| 11 | 2.1.3.5.Суралцагсдын дундах үе тэнгийн дээрэлхэлт, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, сургалтын байгууллагын орчинд цахим эрсдэлээс хамгаалах, дотуур байрын хүүхдийн амьдрах эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг сайжруулж, орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулна. | БГ<br>2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагад хамруулсан суралцагчдын эзлэх хувь<br><br>30<br><br>Нөлөөллийн ажлын хэрэгжилтийн хувь<br><br>90 | 40<br><br>95 | - | 5.0 | Хүүхдийн өөрөө удирдах "Өсвөрийн эмч", "Өсвөрийн санхүүч", "Эко клуб" "Өсвөрийн аварагч", "Номын санч-сурагч","Өсвөрийн цагдаа", "Удирдагч", "Охидын зөвлөл" клубт нийт 76 сурагч хамрагдаж, шинээр "Сэтгүүлч" клуб байгуулахаар бэлтгэл ажлыг 60 хувь хангасан. "Хүүхдээ сонсох өдөр" арга хэмжээг 3, Хүүхдийн чуулган, "Хорт зуршлыг бууруулах, "Үе тэнгийн дээрэлхэлтийг бууруулах" "Эрсдлээс урьдчилан сэргийлэх" зэрэг нөлөөлийн ажлуудыг зохион байгуулж, сурагчдыг 100 хувь хамруулсан. Гадаад дотоод орчны эрсдэлийн үнэлгээг сурагчид, сургуулийн дотоод хяналтын нэгж, эцэг, эхийн зөвлөл, сургуулийн хүүхэд хамнааллын баг 4 удаа хийж, эрдлийг бууруулах арга хэмжээг авч, эрдэлгүй орчинг бүрдүүлсэн. Дотуур байранд амьдарч байгаа суралцагчдын амьдрах орчныг сайжруулах 3.0 сая | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төгрөгийн тохижилт, 1,5 сая төгрөгийн камерын шинэчлэлийг хийсэн. | |
| 12 | 2.1.3.6. Сургууль, цэцэрлэгийн гал тогооны эрүүл ахуйг стандартын шаардлагад нийцүүлэн, хүүхдийн хоолны шим тэжээл, илчлэгийн хэмжээг нэмэгдүүлнэ. | БГ<br><br>2025-2028 | 363.00<br><br>Улсын болон орон нутгийн төсөв, бусад | Туслах аж ахуйтай байгууллагын тоо<br><br>15 | 20 | 187.9 | 187.9 | Хүүхдийн хоолны материал нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 45600.0 мян төгрөгийн тендерийг цахим системээр зарлаж, тендерт шалгарсан "Өгөөмөр Эрдэнэхайрхан" ХХК-тай гэрээ байгуулан мэргэжлийн хоол зүйчдийн боловсруулсан нэгдсэн хоолны цэсийн дагуу үйлчилж байна. Боловсролын яамнаас дэвшүүлсэн "Өдөр бүр нэг аяга сүү" зорилтын хүрээнд цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгөнд тохируулан өдөр бүрийн хоолны цэсэнд сүү, тараг, аарц, ааруул, ээзгийний ундааг оруулж, хүүхдүүддийн хоолноос авах шим тэжээлийг нэмэгдүүлэн дархлааг дэмжиж, үдийн хоол, дотуур байрын хоолны жишиг цэсний дагуу шим тэжээл, илчлэгийн хэмжээг алдагдуулалгүй үйлчилгээ үзүүлэн хоол үйлдвэрлэлийн үйлчилгээг стандартын байр танхимд явуулж, хоол үйлдвэрлэлтэй холбоотой гомдол, санал ирээгүй. | 100 |
| **2.1.4.Багш, удирдах ажилтны мэргэжил, ур чадварыг дээшлүүлж, боловсон хүчний нөөц, нийгмийн баталгааг хангана.** | | | | | | | | | |
| 13 | 2.1.4.1. "Багшийн гурван тулгуур бодлого" цогц арг хэмжээг хэрэгжүүлнэ. | БГ<br><br>2025-2028 | Улсын төсөв | Гүйцэтгэлийн үнэлгээний аймгийн дундаж<br><br>СӨБ-89.5<br>ЕБС-78.1<br>Y-YI дугаар түвшинд үнэлэгдсэн багшийн тоо<br><br>350 | 89.7<br>78.5<br><br>300 | - | - | Цэцэрлэг нь 2024-2025 оны хичээлийн жилд хүүхдийн хөгжлийн үнэлгээг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/280 дугаар тушаалаар батласан журмын дагуу үнэлэхэд бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн дундаж 75 хувийн гүйцэтгэлтэй байсан. Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны А/115 дугаар тушаалын дагуу Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, багшийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулж 5 багш хамрагдсанаас 3 багш 4, 1 багш 5, байгууллагын үнэлгээ 5 дугаар түвшинд үнэлэгдэж, урд оноос үнэлгээ ахисан. Ерөнхий боловсролын сургууль нь мэргэжлийн хөгжлийн 5 бүлэг үйл ажиллагааны дундаж биелэлт 77,5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдэж, багшийн сайн туршлага түгээх "Говь-Эрдэнэ бүс"-ийн арга хэмжээнд "Багшийн хөгжил арга зүйгээс" МХБ-ээс цахим платформыг ашиглах арга зүйг таниулах, Суралцахуйн зорилтоо шинжлэх нээлттэй хичээлийг Баруунбаян-Улаан суманд зохион байгуулсан. 2025-2026 оны хичээлийн жилд бүсийн арга хэмжээг сумандаа зохион байгуулж 5 залуу багш, 6 зэрэгтэй багш нарын сайн туршлагыг түгээж, 6 судлагдахуунаар хэлэлцүүлэгт хичээлийг хийж, багшийн заах арга ур чадвар, арга зүйг дээшлүүлсэн. | |
| 14 | 2.1.4.2. "Багш хөгжлийн ордон"-ыг шинээр байгуулж, Политехник коллеж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг бүрд "Багш хөгжлийн танхим"-ыг бий болгоно. | БГ<br>2025-2028 | 17,800.00<br>Улс, орон нутгийн төсөв | Шинэ<br>Политехник коллеж, ерөнхий боловсролын сургуулиудад багш хөгжлийн төвийг байгуулах 3 | -<br>1 | - | 3.5 | Орон нутгийн төсвийн 3.5 сая төгрөгөөр Цэцэрлэгийн багш нарын өрөөг шинээр байгуулж, тохижуулан, интернэтэд холбон ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан. | 100 |
| 15 | 2.1.4.3. Багш, удирдах ажилтны мэргэжил, арга зүйн тасралтгүй хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг | БГ<br>2025-2028 | 1,000.00<br>Улс, орон нутгийн | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь<br>Шинэ | 30 | 250.00 | 0.8 | Цэцэрлэгийн хэмжээнд судлагдахуунд суурилсан "Хэл яриа", суралцахуйд суурилсан "Эцэг эхийн оролцоо" мэргэжлийн хөгжлийн бүлгүүд ажиллаж, багаар ажиллах чадвар, мэргэжил арга зүйгээ сайжруулж, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах бодлогыг хэрэгжүүлнэ. | | төсөв | | | | | мэргэжлийн багшийн хангалт 80 хувь, мэргэшлийн зэрэгтэй багш 75 хувьд хүрсэн. Мнемо картын онол арга зүй сургалтад 1, зорилгоо тогтвортой, тууштай барих нь сургалтад 5, төлөвлөлт бичих арга зүй сургалтад 1, бийрэн бичлэгийн сургалтад 1, хувь хүний хөгжлийн сургалтад 3, цахим аялал интерактив хичээлийг таниулах, хэрэглээ болгох онлайн сургалтад 1, хиймэл оюун ухааны сургалтад 5, сургалтын шинэчилсэн хөтөлбөр боловсруулах сургалтад 5, хүүхэд хамгааллын сургалтад 1 багшийг хамруулж, томилолт, унаа хоолны зардалд 0.8 сая төгрөгийг олгосон. Ерөнхий боловсролын сургуульд 12 дахь жилдээ ажиллаж байгаа удирдах ажилтны сургалт, захирлуудыг мэргэшүүлэх сургалт, багшийн хөгжил хариуцсан менежерүүдийг чадавхжуулах 3 төрлийн онлайн сургалтад хамрагдаж сертификатаа авч, мэдлэг, ур чадвараа сайжруулсан. | |
| **2.1.5.Сургалтын байгууллагуудын менежментийг сайжруулж, багш, удирдах ажилтны ёс зүйг дээшлүүлнэ.** | | | | | | | | | |
| 16 | 2.1.5.2. Багшийн ёс зүйг эрхэмлэн сахих, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | БГ<br>2025-2028 | 10.00<br>Улсын болон орон нутгийн төсөв | Салбарын хүрээний гомдлын тоо /бууралт/<br>34 | 24 | | | Байгууллагын Ёс зүйн дэд хороо нь 2025 оны ажлын төлөвлөгөөг боловсруулж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г танилцуулах сургалтыг 4 удаа, "Өдрийн цэнэг", "Сайхан үгийн аян" зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулан ёс зүйн зөрчлөөс 100 хувь урьдчилан сэргийлсэн. Говь-Эрдэнэ бүсийн цэцэрлэгүүдийн туршлага солилцох уулзалт, өдөрлөгийг Баруунбаян-Улаан суманд зохион | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгуулж "Ёс зүйн дэд хороо"-ны тайланг танилцуулан, хэлэлцүүлгийг хийж, туршлага солилцсон. Амжилт гаргасан багш бүрийн амжилтыг цахимаар сурталчилж, байгууллагын соёл-багшийн ёс зүйн хүрээнд байгууллагын ёс зүйн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж соён гэгээрүүлэх зорилтот 5 үйл ажиллагааг зохион байгуулсан давхардсан тоогоор 126 багш ажилтан хамрагдан, багшийн ёс зүйн зөрчил гаргасан 2 багшид сануулах арга хэмжээг авсан. Байгууллагын соёлын хүрээнд өглөөний мэндчилгээг анги бүр хуваарийн дагуу угтaлт хийж хэвшсэн, багш ажилчид биеийн тамирын хувцас, дүрэмт хувцсаар жигдэрч, байгууллагын эерэг, нийтэч уур амьсгалыг бүрдүүлсэн. | |
| **2.1.6.Иргэдийн насан туршдаа тасралтгүй суралцахуйг дэмжин, сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | |
| 17 | 2.1.6.1. Насан туршийн боловсролын үндсэн чиглэлийг хөгжүүлж, албан бус сургалтыг зохион байгуулна. | НТСТ<br>2025-2028 | 32.00<br>Улсын болон орон нутгийн төсөв | сургалт, нөлөөлийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн эзлэх хувь 21.4 | 22.5 | 8.00 | . | 2024-2025 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрт 11 суралцагч хамрагдаж суурь боловсролын гэрчилгээг 2, бүрэн дунд боловсролыг гэрчилгээг 1 суралцагч авсан. 2025-2026 хичээлийн жилийн дүйцсэн хөтөлбөрт 12 суралцагч бүртгэгдэж, сургалтад хамрагдсан. | 70 |
| 18 | 2.1.6.3. ESEL хөтөлбөр, өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох арга зүйг түгээн дэлгэрүүлж, нутагшуулна. | НТСТ<br>2025-2028 | 10.00<br>.<br>Улсын болон орон нутгийн төсөв | Сургалтад шинээр хамрагдсан оролцогчид 200<br>Төсөл бичиж оролцсон оролцогчид 10 | *180*<br>20 | 5.00 | 2.6 | ESEL хөтөлбөрийн хүрээнд "Mongolian calligraphy" 2.6 сая, "Мэргэн шавь" шагайн харваа 2,6 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулсан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | 2.1.6.4. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүл иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, суралцагч сум, баг, байгууллагыг дэмжин ажиллана. | НТСТ 2025-2028 | 10.00 . Улсын болон орон нутгийн төсөв | Төсөл бичиж оролцсон оролцогчдын тоогоор 10 | 20 | | | Урилгат хичээл 1 аяны хүрээнд 138 эцэг эх асран хамгаалагчид багшийн хичээлд багшийн заах арга зүйтэй танилцах, хүүхдийнхээ сурах орчин, сурах арга барилтай танилцах зорилгоор 14 хоногийн хугацаанд нээлттэйгээр урьж суулган, сэтгэгдлийг сонсч цаашид хэрэгжүүлэх саналыг хүлээн авсан. "Сургууль миний хүүхдийн хоёр дахь гэр" челленж 9,10 дахь үйл ажиллагааны хүрээнд 2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, эцэг эхийн хандив тусламжаар 4 ангийн шалыг пракеталсан. Дотуур байранд эцэг эхийн уулзалтын өрөөг шинээр тохижуулж хүүхэдтэйгээ уулзах, хонох боломжийг бүрдүүлж, НУЗАН, БУЗАН-ийн удирдлагын багаас эцэг, эхийн өдөрлөг үйл ажиллагааг 3 удаа зохион байгуулж, байгууллагын сургалт үйл ажиллагааг сурталчилсан. | 100 |
| **2.2. ЭРҮҮЛ МЭНД** | | | | | | | | | |
| **2.2.1.Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | |
| 20 | 2.2.1.2. Халдварт бус өвчнөөс сэргийлэх "Эрүүл Монгол" хөтөлбөрийг салбар дундын оролцоотойгоор хувь хүн, гэр бүл, байгууллага, аж ахуйн нэгжийн хүрээнд хэрэгжүүлнэ. | ЭМГ 2025-2028 | 1,997.00 | Эрт үедээ оношилогдсон хавдрын эзлэх хувь 55.1 18 хүртэлх насны хүүхдийн шүдний өвчлөлийн эрүүлжүүлэлтийн хувь | 55.2 70 | | | "Хэнийг ч орхигдуулахгүй байх" урьдчилан сэргийлэх үзлэг, явуулын амбулаторийн үйлчилгээг хүн амынхаа эрүүл мэндийг сайжруулах, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийг эрт илрүүлэх, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн тусламж үйчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, төрийн албан хаагчид, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд, малчид зэрэг 5989 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд оруулж, цусны | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эрүүл монгол арга хэмжээний хэрэгжилт хувь -70 | 80 | | | даралт ихсэлт, чихрийн шижин, хөх, умайн хүзүүний хавдар илрүүлэх эрт илрүүлгийн үзлэг, цус, шээсний ерөнхий болон, биохими, үений үрэвсэл, өлөн үеийн сахар, сахарын 3 сарын дундаж үзэх, витамин Д хангалт тогтоох, элэгний В, С вирус илрүүлэх, илэрсэн тохиолдолд В, С вирус тоолох, хеликобактер илрүүлэх, тоолох, ЭКГ зэрэг шинжилгээнүүд, эрүүл мэндийн үзлэг, эрүүл зохистой хооллолт, хот зуршил, идэвхтэй хөдөлгөөн, стресс зэрэг сургалтад хамруулсан. Шинжилгээнд хамрагдсан иргэдийн өвчлөлийн 46 хувьд эмчилгээ хийж, шүдний өвчлөлийг 16 хувиар бууруулсан. | |
| 21 | 2.2.1.3. "Эрт илрүүлэг 2" арга хэмжээний хүрээг зорилтот бүлэгт чиглүүлж, эмчилгээ, хяналт, урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | ЭМГ<br><br>2025-2028 | 23,050.00<br><br>Улсын ЭМД-ын сан | эрт илрүүлэгт хамрагдалтын хувь<br><br>Ураг, нярайн<br><br>3-5 настай хүүхдүүд<br><br>6 настнууд<br><br>7-18 | 70<br><br>80<br><br>90<br><br>80 | | | Артерийн даралт ихсэлтийн эрт илрүүлэгт хамрагдвал зохих 1,193 иргэнээс 745 иргэн хамрагдаж, хамралтын хувь 62, чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт хамрагдвал зохих 770 иргэнээс 427 иргэн хамрагдаж, хамралтын хувь 55,5, хөхний хавдрын эрт илрүүлэгт хамрагдвал зохих 368 иргэнээс 208 иргэн хамрагдаж, хамралтын хувь 56,5, умай хүзүүний хавдрын эрт илрүүлэгт хамрагдвал зохих 105 иргэнээс, 41 иргэн хамрагдаж, хамралтын хувь 39, 2025 онд төрсөн 18 нярайн эрэлт 100 хувь, 3-5 насны 49 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан томуугийн дархлаажуулалтыг 100 хувь хийж, 6-18 насны 283 хүүхдийн амны хөндий, нүд, биеийн ерөнхий өвчлөл илрүүлэх урьчдилан сэргийлэх үзлэгт хамруулж, зөвлөгөө мэдээллийг хүргэсэн. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | 2.2.1.4. Өвчлөл, нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлсийн тархалтыг тогтоож, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | ЭМГ<br>2025-2028 | 541.00<br>Улсын болон орон нутгийн төсөв, ОУБ-ын хандив, тусламж | Зүрх судасны шалтгаант нас баралтын түвшин (10000 хүн амд)-19<br>Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10000 хүн амд)-12.2<br>Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын түвшин (10000 хүн амд)-5<br>Нийт нас баралтын түвшин (1000 хүн амд)-4.9 | 18.7<br>11.9<br>4.9<br>4.6 | 120.00 | | Зүрх судасны өвчлөлийн нас баралт 4 тохиолдол бүртгэгдэж 14,7 хувь буюу улсын дунджаас 0,7 хувиар бага, аймгийн дунджаас 2,9 хувиар их үзүүлэлттэй, хорт хавдарын шалтгаант нас баралт 1 буюу 4,9 хувь улс аймгийн дунджаас бага үзүүлэлтэй, осол гэмтлийн шалтгаант нас баралт 1 буюу 4,9 хувь улс аймгийн дунджаас бага үзүүлэлтэй, нийт 6 нас баралт бүртгэгдсэн. Урьдчилан сэргийлэх буюу авсан хариу арга хэмжээг электрон тамхины хор уршиг сургалтыг 2 удаа 389 иргэнд, "Агшин бүрт анхаарал сэрэмжийг нэмж-эрсдлийг бууруулая"" осол гэмтлээс сэргийлэх сарын аян 256 иргэнд сургалт, 0-5 насны хүүхэдтэй 42 өрхөд гэр нэлгээг хийж эрсдлийг бууруулсан Хөдөөгийн багуудад "Хэнийг ч орхигдуулах байх" явуулын тусламж үйлчилгээг 2-3 удаа зохион байгуулж, Бүртгэл хөтөлж, тайлан мэдээг аймгийн Эрүүл мэндийн газар хүргүүлсэн. | 70 |
| **2.2.2.Эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг дээшлүүлэх, иргэдийг орон нутагтаа өндөр өртөгтэй нарийн мэргэшлийн тусламжийг авах боломжийг бүрдүүлснээр санхүүгийн болон цаг хугацааны хүлээгдэл чирэгдлийг бууруулна.** | | | | | | | | | |
| 23 | 2.2.2.3. Уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж, | ЭМГ<br>2025-2028 | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Мэргэшсэн эмч мэргэжилтний тоо<br>Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | | | | Орчин үеийн анагаах ухаантай хослуулан бариа засал, УВЧ, искра, соллюкс, потокс, парафин, бумба засал, сам соруул, төөнүүр уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээг 95 хүнд үзүүлсэн. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | уламжлалт эмийн хэрэглээг нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| 24 | 2.2.2.4.Үндэсний эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санд орох мэдээллийг олон улсын стандартын дагуу цуглуулж, түүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | ЭМГ<br>2025-2028 | 800.00<br>Улсын төсөв | Эргэн мэдээллийн тоо<br>12 | 12 | | | Hinfo программд эмч нарын үзлэг, төрөх, нас баралт, өвчтөний түүх, эрт илрүүлэгийн үзлэг, осол гэмтлийн мэдээ зэргийг сар бүр оруулж, хэвшсэн. | 100 |
| 25 | 2.2.2.5. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон сумдын эрүүл мэндийн төвүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | ЭМГ<br>2025-2028 | 330.00<br>Улсын төсөв, төсөл хөтөлбөр | ISO-9001 Стандарт нэвтрүүлсэн батламжлагдсан байгууллагын тоо-2<br>MNS 7014:2023 Стандарт шаардлага хангасан байгууллагын тоо-0 | 3<br>3 | | | MNS 7014:2023 стандартын дагуу Эрүүл мэндийн төвийг үнэлэх ажлын хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 100 хайлаас тарьж, гадна крилл болон монгол бичгээр гэрэлтэй хаягжуулалт хийн эмнэлгийн амбулатори, шинжилгээ өгөх хэсэгт эх нялхаст зориулсан дэмжлэгт орчин бүрдүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх өрөөний хаягийг зайнаас, 2 талаас харагдах кирилл үсгээр бичсэн хаягжилтыг хийсэн. Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны А/11 тоот тушаалаар үйлчлүүлэгчийг дэмжих, орон тооны бус зөвлөлийг байгуулж, үйлчилгээ авах, үзүүлэх ээлтэй, хүртээмжтэй үйл ажиллагааг зохицуулах журмыг боловсруулан мөрдүүлж, эмнэлгийн хүлээн авах, яаралтай тусламжийн тасгийн байршил заасан тэмдэг, тэмдэглэгээ, дуугүй хөтөчийн хаягжилтийг хийж, йлчлүүлэгч нар эмнэлгийн ажилтнуудаас зөвлөгөө, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | өрөө, тасалгааны хана, шаланд дуугүй хөтөчийг байрулууж, дархлаажуулалт, төрсний дараах өрөөг хүүхдийн анхаарал татахуйц зураг, дүрсүүд, стандартад нийцсэн угааж болдог ханын стикерээр чимэглэн тохижуулсан. | |
| **2.2.3.Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдал, худалдан авалт, үнийн бодлогын хэрэгжилтийг хангаж, эмийн зохистой хэрэглээг дээшлүүлнэ.** | | | | | | | | | |
| 26 | 2.2.3.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ, худалдан авалт, ил тод байдлыг хангуулан, жорын талаарх нэгдсэн мэдээллийн санг бүрэн ашиглаж, эмийн эмчилгээний үр ашиг, үр дүнг тооцож ажиллана. | ЭМГ 2025-2028 | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Цахим программ нэвтрүүлсэн байгууллагын хувь Нэг эх үүсвэрээс худалдан авалт хийсэн байгууллагын тоо-0 | - <60 | - | 59.4 | Эм ханган нийлүүлэх 2 байгууллагатай гэрээ хийж, эм эмнэлгийн хэрэгслийн 200 гаруй нэр төрлийн 59.4 сая төгрөгний шууд худалдан авалтыг хийсэн. | 100 |
| 27 | 2.2.3.2. Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, тандалт, судалгаа шинжилгээний ажлыг дэмжин, антибиотикийн зохистой хэрэглээнд хяналт тавина. | ЭМГ 2025-2028 | 525.00 Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Үнэлгээний хувь Антибиотикийн хэрэглээний хувь-0 Эрдмийн бүтээлийн тоо-0 | 0 <3 | | | Антибиотикийн хэрэглээг багасгаж, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, антибиотикийн дасан зохицолоос урьдчилан сэргийлэх тушаал, шийдвэр, журам, зааврууд, аймгийн Эрүүл мэндийгн газраас зохион байгууллагддаг сургалтуудыг эмч, мэргэжилтэнүүдэд жилд 2 удаа зохион байгуулж судалгаа хийснээр антибиотикийн хэрэглээг 1.5 хувиар бууруулж, 271 хэвтэн эмчлүүлэгчээс 264 иргэнд 1, 2 төрлийн антибиотик эмчилгээ хийсэн. | 100 |
| **2.2.4.Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, нийгмийн баталгааг сайжруулж, эрүүл мэндийн ажилтны чадамжид суурилсан бүтээмжийг тасралтгүй дээшлүүлнэ.** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | 2.2.4.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, хөгжил, нийгмийн баталгааг сайжруулах аймгийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ. | ЭМГ<br><br>2025-2028 | Улсын болон орон нутгийн төсөв, ОУБ-ын хандив, тусламж | 10000 хүн амд ногдох эмч/ сувилагч<br><br>28.8 /эмч/ 34.9/сувилагч/ | 29.2 /эмч/ 35.2/сувилагч/ | - | 5.6 | Суманд дутагдалтай байгаа, нэн шаардлагатай ерөнхий болон нарийн мэргэжлээр ирж ажиллаж байгаа 2 эмчийг ажиллах хугацаанд нь үнэ төлбөргүй орон байр, өвлийн идэшээр хангасан. Багийн эмчгүй 1 багийг 1 их эмчид хариуцуулан, хавсран ажилласны 40 хувийн нэмэгдэл олгож, нийт 4.7 сая төгрөгийг зарцуулсан. Манлайлал, харилцаа, хандлага зан үйл, ёс зүй, цагийн менежмент, хувь хүний болон мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад цахимаар 11 удаа давхардсан тоогоор 56, танхимаар 14 удаа давхардсан тоогоор 41 ажилтан хамрагдаж 2.1 сая төгрөг зарцуулсан. Эрүүл мэндийн төвийн ажилтан, албан хаагчид, үйлчлүүлэгчдэд ая тухтай байх боломжийг бүрдүүлэх зорилгоор 3.5 сая төгрөгний тохижилт хийж, орчин нөхцлөө сайжруулсан. | 100 |
| 29 | 2.2.4.3. Хархорин, Баянгол, Баруунбаян-Улаан, Өлзийт, Гучин-Ус, Төгрөг сумдын эмч нарыг нийтийн орон сууцаар, хөдөөгийн багийн төвд байнгын оршин суудаг эмч нарыг жижиг оврын автомашин, мотоциклоор үе шаттай хангана. | ЭМГ<br><br>2025-2028 | 950.00<br><br>Улсын болон орон нутгийн төсөв | Эмч, Мэргэжилтний байртай болсон сумын тоо-12<br><br>Багийн эмчийн унааны тоо -0 | 2<br><br>3 | - | - | Япон улсын “Өвсний үндэс” хөтөлбөрөөр туулах чадвар сайтай түргэн тусламжийн автомашинтай болох төсөл дэмжигдэж, автомашины шинэчлэлт хийхээр хүн ам, алсмагдал нутаг дэвсгэртэй 2 дугаар багийн эмчийг унаажуулахаар төлөвлөсөн. | 50 |
| **2.3.ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ** | | | | | | | | | |
| **2.3.1.Гэр бүлд ээлтэй, тэгш хүртээмжтэй цогц арга хэмжээг хэрэгжүүлж, түр хамгаалах байрны ая тухыг сайжруулан шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | 2.3.1.1. Гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах зорилгоор "Халуун ам бүл" төслийг хэрэгжүүлнэ. | ХГБХХГ<br>2025-2028 | 300.00<br>Орон нутгийн төсөв | Батлагдсан төсөл-шинэ | 1 | - | - | Халуун ам бүл төслийн төлөвлөгөөнд оруулахаар гэр бүлд чиглэсэн үйлчилгээг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр цахим орчин дахь соёлтой харилцаа, аюулгүй байдлыг түгээн дэлгэрүүлэх, гэр бүлийн харилцаан дахь жендэрийн асуудлын чиглэлээр хийж хэрэгжүүлэх арга хэмжээ, гэр бүлийн гишүүдэд шашны болон философын шинжлэх ухааны мэдээлэл, сургалтыг хийж, саналыг хүргүүлсэн. | 30 |
| 31 | 2.3.1.2. Эрүүл нийгмийг бүтээхэд эрчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний онцлог хэрэгцээ, тулгамдаж буй асуудлыг судлан тогтоож, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | ХГБХХГ<br>2025-2028 | 28.00<br>Улс, орон нутгийн төсөв | Насанд хүрсэн эрэгтэйчүүдийн оролцоо-450 | 400 | | | 2025 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаар цэргийн насны 76 залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, насан туршийн суралцахуйн төв, Гэр бүл, хүүхэд хамгааллын газартай хамтран гэр бүлийн үнэ цэнэ, эрчүүдэд тулгамдаж буй асуудлаар сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал бодлыг нь сонссож, шийдвэрлэсэн. Нийтийн арга хэмжээнд оролцох эрчүүдийн идэвх, оролцоо нэмэгдэж, адуучин, тэмээчдийн холбоог иргэдийн санаачлагаар шинээр байгуулж, үйл ажиллагаа нь тогтворжиж, адуу, тэмээний соёлыг түгээн дэлгэрүүлэх 8 арга хэмжээг зохион байгуулж, 1 видео шторк хийж, нийтэд сурталчилсан. | 90 |
| **2.3.2.Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх бодлогыг салбар дундын хамтын ажиллагаатай хэрэгжүүлж, хүүхэд хамгааллыг сайжруулна.** | | | | | | | | | |
| 32 | 2.3.2.1. "Хайрлагдсан хүүхэд" төслийг хэрэгжүүлж, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулна. | ХГБХХГ<br>2025-2028 | 300.00<br>Орон нутгийн төсөв | Батлагдсан төсөл-шинэ | 1 | - | - | Хайрлагдсан хүүхэд төслийн төлөвлөгөө боловсруулах шатанд явж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд сумандаа эцэг, эх, асран хамгаалагчидад харилцаа хандлага ёс зүйн боловсрол олгох, сэтгэл зүйчтэй болох гэсэн 2 санал хүргүүлсэн. | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | 2.3.2.2. Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэлд өртөх, хорт зуршилд автахаас урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг бий болгох зорилгоор нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулна. | ХГБХХГ 2025-2028 | 20.00 Улс, орон нутгийн төсөв | Нөлөөллийн арга хэмжээний тоо-6 | 5 | - | - | Хүүхэд өсвөр үеийн осол гэмтэлд өртөх хорт зуршилд автахаас урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг бий болгох зорилгоор хүүхдийн эрх хамгаалал, эерэг хандлага-зөв дадал сэдвийн хүрээнд ЕБС-ийн дунд, ахлах анги, дотуур байрын нийт 160 сурагчдад 1 сургалт нөлөөлийн ажиллагаа зохион байгуулсан. Утаат болон электрон тамхины хэрэглээний талаар ахлах ангийн сурагчдад тандалт судалгаа хийж, 6 хүүхдийг илрүүлэн, хариу арга хэмжээ авч, хорт зуршлын талаар мэдээлэл хийж, зөвлөгөө өгсөн. | 70 |
| 34 | 2.3.2.4. Сум бүрд нийгмийн ажилтан ажиллуулна. | ХГБХХГ 2025-2028 | 350.00 Улсын төсөв | нийгмийн ажилтан | 36 | 86.80 | - | Нийгмийн ажилтны шинэ орон тоонд 1 хүнийг авч ажиллуулсан. | 100 |
| **2.3.3.Залуучуудын бүх талын хөгжилд дэмжлэг үзүүлж, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | |
| 35 | 2.3.3.1. Залуучуудын боловсролын болон мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог дэмжсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | СУАЖЗ 2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | Хамрагдсан залуучуудын тоо-450 | 1050 | - | | Улаанбаатар хот дахь Гучин-Ус сумын оюутан залуучуудын холбоог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг тогтвортой явуулах талаар зөвлөгөө мэдээлэл өгч, 2015-2024 онд Ерөнхий боловсролын сургууль төгссөн залуучуудын суралцаж байгаа болон төгссөн сургууль, мэргэжил, эрхэлдэг ажил, оршин суух хаягийн судалгааг 300 оюутан залуучуудаас авсан. Жил бүр уламжлал болгон 2 оюутанд сурлагын дүн, кридит оноог нь харгалзан тус бүрт сургалтын төлбөрийн 1.0 сая төгрөгийг хандивладаг 1 иргэнтэй хамтран ажиллаж, түүний хийж буй сайн үйлсийг нийтэд сурталчилсан. Намрын нээлт үүргэвчтэй аялалыг 17 оюутан залуучуудтай зохион байгуулж, Улаанбаатар хот дахь Гучин-Ус сумын оюутан залуучуудын холбоондоо | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | шинээр 2 гишүүнийг сонгон авч элсүүлсэн. | |
| 36 | 2.3.3.2. Залуучуудад гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Аз жаргалтай гэр бүл" сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж, залуучуудын хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | СУАЖЗ<br><br>2025-2028 | 8.00<br><br>Улс, орон нутгийн төсөв | Хамрагдсан гэр бүлийн тоо | 5 | - | - | Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулаагүй. | 0 |
| 37 | 2.3.3.3. Зорилтот бүлгийн залуучуудыг хөгжлийн үйлчилгээнд хамруулах, "Залуусын боломж" явуулын үйлчилгээг нэвтрүүлж, хөдөөгийн залуучуудын хөгжил оролцоог нэмэгдүүлнэ. | СУАЖЗ<br><br>2025-2028 | 30.00<br><br>Улс, орон нутгийн төсөв | Хамрагдсан залуучуудын тоо | 400 | - | - | Залуучуудын хөгжлийн зөвлөлийг 11 гишүүнтэйгээр шинэчлэн байгуулж, ажлын төлөвлөгөөний хүрээнд 3 цахим, 2 төрлийн гарын авлага боловсруулан тарааж, 325 хандалт авсан. Зорилтот бүлгийн 3 өрхөд түлээ, түлшний тусламж үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг дэмжих зорилгоор 1 сургалт, тэмцээн зохион байгуулж, 10 иргэнийг хамруулсан. | 100 |
| 38 | 2.3.3.4. Төрийн бүх шатны байгууллага залуу албан хаагчдыг сургах, дадлагажуулах, ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | СУАЖЗ<br><br>2025-2028 | Улсын төсөв | Байгууллагын дэргэдэх залуучуудын хөгжлийн зөвлөл -10<br>Хамрагдсан залуучуудын тоо 98 | 15<br><br>180 | - | - | Шинээр ажилд орсон 4 албан хаагчийг ажлын байранд нь практикаар дадлагжуулан, төрийн албан хаагчийн дагаж мөрдөх хууль, журам, дүрмийн сургалтыг тус бүрт 2 удаа зохион байгуулж, тухай бүрт зөвлөн туслаж, зөрчил, дутагдал гараагүй. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 39 | 2.3.3.5. Төр, иргэний нийгмийн болон зорилтот бүлгийн иргэд рүү чиглэсэн сайн дурын ажил, санал санаачилгыг бүх талаар дэмжинэ. | СУАЖЗ<br><br>2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 20 | 40 | - | "Монгол Ви И Ти Нет" төрийн бус байгууллагаас зохион байгуулсан "Хайрын бэлэг" төсөлд 2 аж ахуй нэгж нэгдэн зорилтот бүлгийн 8 өрх тус бүрт 4 хонь хандивлаж, амьжиргааны түвшин доогуур өрхүүдэд бодит дэмжлэг үзүүлж, сайн дурын үйл ажиллагааг дэмжин сайн дурын хөдөлгөөнийг тогтмолжуулах, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах сайн туршлага болсон. | 100 |
| **2.4.ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ** | | | | | | | | | |
| **2.4.1.Соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулна.** | | | | | | | | | |
| 40 | 2.4.1.1. Соёлын биет болон биет бус өвийг судлан шинжлэх, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах, хамгаалах бодлогыг хэрэгжүүлнэ. | СУАЖЗ<br><br>2025-2028 | 71.00<br><br>Улс, орон нутгийн төсөв | Судалгааны тоо-0<br><br>Өвлөн Уламжлагчийн тоо 250 | 1<br><br>300 | - | 1.3 | Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан Ерөөлч, магтаалчдын олон улсын анхдугаар их наадмын нээлтийн арга хэмжээний тайз, дэлгэц, дууны төхөөрөмжийг бэлтгэн ажиллуулж оролцсон бөгөөд 1 өвлөн уламжлагчийг уралдаанд бэлтгэн оролцуулсан. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нарыг сурталчлах, хөгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээний нэгдсэн 2 удаагийн арга хэмжээнд 2, аймаг болон бүсийн хэмжээний уралдаанд 8 авьяастныг оролцуулж бий биелгээ, ардын хөгжмийн төрлүүдэд эхний байруудыг эзэлсэн. | 100 |
| 41 | 2.4.1.5. Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлж, сумдад морин хуурын шавь сургалтыг зохион байгуулж, өсвөрийн морин хуур чуулгын үйл ажиллагааг | СУАЖЗ<br><br>2025-2028 | 221.00<br><br>Улс, орон нутгийн төсөв | Өсвөрийн морин хуурчдын тоо-15<br><br>шавь сургалтыг дэмжих нэгдсэн арга хэмжээ | 20<br><br>2 | - | 4.3 | Морин хуурын сургалтад анхлан суралцагчдыг хамруулж, 7-58 насны 15 суралцагч хамруулж, шавь сургалтыг хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдах зорилгоор хөгжмийн багш, морин хуурч мэргэжлээр суралцагч, төгсөх ангийн оюутанд сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсэн. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэмжин ажиллана. | | | | | | | | |
| 2.4.2.Бүх нийтийн соёлын боловсролыг олгох үйл ажиллагааг орон нутгийн онцлогт тохируулан шинэлэг арга хэлбэр ашиглан хөгжүүлнэ. | | | | | | | | | |
| 42 | 2.4.2.1. Үндэсний соёлын өв түүх, хэл соёл, ёс заншилд тулгуурлан "Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээг хэрэгжүүлж, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна. | СУАЖЗ<br><br>2025-2028 | 177.50<br><br>Улс, орон нутгийн төсөв | "Бүх нийтийн соёлын боловсрол II" арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо 1000Үндэсний бичгийн хэрэглээ, чадавхийг сайжруулах сургалтад хамрагдсан иргэдийн тоо 1100 | 5000<br><br>1000 | - | 10.0 | Бүх нийтийн соёлын боловсрол олгох зорилгоор бүжгийн дугуйланд 45 хүүхэд, морин хуурын дугуйланд 15 хүүхэд хамрагдаж, тайлан тоглолтоо хийхээр бэлтгэл хангагдаж байна. Иргэд, төрийн албан хаагчид, дугуйлангийн сурагчдыг аймаг, бүс, сумын 6 уралдаан, 16 арга хэмжээнд бэлтгэн оролцуулж, шинээр цахилгаан хөгжим, дуу, үндэсний хөгжим, эвлүүлэгчийн дугуйланг нээн, ур чадвараар шалгаруулан авч, нийт 23 хүүхдийг элсүүлсэн. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн хэрэглээ, чадавхийг бататгах зорилгоор хос бичгээр "Үсэг бүрийн үнэ" үсэглэлийн аварга 2025 уралдааныг зохион байгуулж аваргуудыг тодруулсан. | 90 |
| 43 | 2.4.2.2. Иргэдийг соён гэгээрүүлэх зорилгоор үндэсний мэргэжлийн урлагийн байгууллага болон шилдэг уран бүтээлчдийн уран бүтээлүүдийг орон нутагт урьж хамтран ажиллана. | СУАЖЗ<br><br>2025-2028 | 390.00<br><br>Улс, орон нутгийн төсөв | Уран Бүтээлийн Тоо<br><br>Үзэгчдийн тоо | 1<br><br>1200 | - | 1.8 | Орон нутагт театрын урлагийн сурталчлах ажлыг хүрээнд сумын Засаг даргын ивээл дор аймгийн Хөгжимт драмын театрын драм ангийн жүжигчдийн уран бүтээлийг урьж ирүүлэх хүсэлтийг явуулж бэлтгэл ажлыг 65 хувь хангасан. Бүжгийн дугуйлангийн сурагчдын тайлан тоглолтод Хөгжимт драмын театрын дэргэдэх өсвөрийн морин хуурын хамлаг, Ш.Лозвойн нэрэмжит уран уншлагын аймгийн уралдаанд мэргэжлийн урлагийн байгууллагын 3 жүжигчнийг урьж ирүүлэн шүүгчээр ажиллуулж хамтран ажилласан. | 100 |
| 44 | 2.4.2.3. Номын сангийн үйлчилгээг цахим | СУАЖЗ | 300.00 | Электрон каталогид оруулсан | 60 | 0.3 | 0.3 | Номын сангийн үйлчилгээг 100 хувь электрон катологид шилжүүлж, 6,781 номыг цахимжуулж 781 номоор 187 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлбэрт шилжүүлэн, аймгийн Төв номын сангийн сан хөмрөгт жил бүр 10.0-аас доошгүй, сумдын Соёлын төвийн номын сангийн сан хөмрөгт 2.0-оос доошгүй сая төгрөгөөр баяжилт хийнэ. | 2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | хувь 50 Шинэ номын тоо 500 Уншигчийн тоо 20000 | 700 21000 | | | уншигчид үйлчилэн мэдлэг, ур чадварыг сайжруулж, соён гэгээрүүлсэн. | |
| 2.4.3.Соёл, урлагийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, мэргэжлийн урлагийн байгууллагын үйл ажиллагааны менежментийг сайжруулан хүний нөөцийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | |
| 45 | 2.4.3.1. Соёл, урлагийн байгууллагын орчин нөхцөлийг сайжруулан, тоног төхөөрөмжөөр хангаң ажиллана. | СУАЖ3 2025-2028 | 1,216.00 Улс, орон нутгийн төсөв | Тоног Төхөөрөмж, барилгын их засварын гүйцэтгэл 0 | 50 хүртэл хувь | 10.0 | 10.0 | Хөгжим, бүжгийн ангийн засвар үйлчилгээ, тохижилтыг хийж, багш нарын ажиллах нөхцлийг сайжруулан дугуйлангийн сурагчдын хичээллэх таатай орчинг бүрдүүлсэн. | 100 |
| 2.5.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ | | | | | | | | | |
| 2.5.1.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн салбар хоорондын хамтын ажиллагаа, бодлогын уялдааг хангах замаар 5000-аас доошгүй ажлын байр бий болгоно. | | | | | | | | | |
| 46 | 2.5.1.2. Хөдөлмөр зуучлалын үйлчилгээг дэмжин цагийн ажлын тогтолцоог бий болгоно. | ХХҮГ 2025-202820 | Улс, орон нутгийн төсөв | журмын төсөл 0 Ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо | 1 - | - | - | Хөдөлмөр эрхлэх ур чадварын бэлэн байдлын үнэлгээ (профайлинг)-ний аргачлалын дагуу иргэнд 5 хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээг хийж, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулсан. Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдээс нийт 1 ажлын байрны захиалга хүлээн авч 8 иргэнийг түр ажлын байранд зуучилсан. Цагийн ажилтан авч ажиллуулах боломжтой 5 аж ахуйн нэгж байгууллагатай уулзалт хийж цагийн ажлын тогтолцоо, | 100 |

| 29 | 3.3.1.1. "Цагаан алт" үндэсний хөдөлгөөний хүрээнд арьс шир, ноос, ноолуур зэрэг малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжинэ. | ХХААГ<br>2025-2028 | 2,400.00<br>Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр, хувийн хэвшил | Дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо 4<br>Үйлдвэрлэлийн хэмжээ, сая төг 12,048.50<br>Борлуулалтын хэмжээ, сая төг 10,655.10 | 3<br>12,409.90<br>10,974.70 | | | "Гучин-Усчууд үйлдвэрлэв" намрын үзэсгэлэн худалдаанд арьс, шир, ноос, ноолуурын гаралтай бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжин, тэдний бараа бүтээгдэхүүнийг сурталчлан борлуулах арга хэмжээнд хамруулж, зах зээлд хүрэх сувгийг өргөжүүлсэн. Суманд үйл ажиллагаа явуулж буй "Дэвжих" эсгийний үйлдвэр нь намрын улиралд ноосны бүтэц нарийн, цэвэр, богино, задралт сайтай учраас малчдаас хонь, хурганы ноос худалдан авч, эсгийг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэн Богд, Баруунбаян-Улаан, Төгрөг, Хайрхандулаан сумд болон Өвөрхангай аймгийн гэр ахуйн худалдаа эрхлэгчдэд нийт 220 эсгийг нэгийг нь 130,000 төгрөгөөр нийлүүлж, орон нутгийнхаа эсгийний хэрэгцээг хангаж, орлогоо өмнөх жилээс 25 хувиар сайжруулсан. | 50 |
| 30 | 3.3.1.4. "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлэн өрнүүлж, гол нэр төрлийн | ХХААГ<br>2025-2028 | 3.200.00 Улсын төсөв Орон нутгийн | Үйлдвэрлэлтийн хэмжээ, сая төг 23,132.30 | 24288.9 | | | Сумын хэмжээнд үйлдвэрлэл эрхэлж буй байгууллага, иргэдийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр "Гучин-Усын намар" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, аймгийн үзэсгэлэн худалдаанд оёмол бүтээгдэхүүний | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлнэ. | | төсөв, Хөнгөлөлттэй зээл, хувийн хэвшил | Борлуулалтын хэмжээ, сая төг 28,597.60 Экспортолсон махны хэмжээ, тн 155.3 | 30,027.50 170.8 | | | чиглэлээр 1 иргэн, сүү цагаан идээгээр 1 иргэн, тариалсан төмс, хүнсний ногоогоо худалдаалахаар 1 иргэн тус тус оролцсон. Гэрийн эсгий үйлдвэрлэдэг төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, бүтээгдэхүүний борлуулалтыг сумын хэмжээнд төдийгүй зэргэлдээх сумдын малчдад нийлүүлэх ажлыг зохион байгуулан суталчилж, санхүүгийн эх үүсвэрийг 50 хувиар нэмэгдүүлсэн. Орон нутгийн мах, махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ, хүнсний ногоо зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг төсвийн байгууллагуудын хоолны тендерт шалгарсан "Өгөөмөр-Эрдэнэ хайрхан" ХХК-иар дамжуулан худалдан борлуулалтыг хийсэн. Энэхүү арга хэмжээ нь орон нутгийн үйлдвэрлэгчдийн орлогыг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжихэд бодит хувь нэмэр оруулсан. | |
| 31 | 3.3.1.5. Үйлдвэрийн аргаар төхөөрч, бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжих замаар махны үйлдвэр, мал төхөөрөх цехүүдийн үйл ажиллагааг тогтворжуулна. | ХХААГ 2025-2028 | 950.00 Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хөнгөлөлттэй зээл, хувийн хэвшил | Дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо 2 Төхөөрсөн малын тоо 14250 Бэлтгэсэн махны хэмжээ, тн 349.0 | 4 21375 523.5 | | | Сумын мал нядалгааны цехээр 3,500 малыг төхөөрч бэлтгэн гарал үүслийн гэрчилгээ авч, зах зээлд болон Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн хоолны махны хэрэглээг 100 хувь хангаж байна. Мах, сүүг улирал тутамд мал эмнэлгийн лабораторид шинжлүүлж, шинэлэг байдал, антибиотикийн үлдэгдэл байгаа эсэхийг тодорхойлуулахад хүүхдийн хоолонд хэрэглэхэд аюулгүй дүгнэлт гарсан. | 90 |
| 32 | 3.3.1.7. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулна. | ХХААГ 2025-2028 | Төсөл, хөтөлбөр, хувийн хэвшил | Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо 1331 | | | | Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах чиглэлээр иргэд, худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2000 | | | "Эрүүл сав-эрүүл хүнс" эрүүл ахуйн зөвлөмж, мэдээлэл, хүнсний зориулалтын сав баглаа боодлын стандартын талаар аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэстэй хамтран сургалт зохион байгуулсан. Мөн иргэдэд зориулсан нөлөөллийн постеруудыг сумын пэйж, хуудсуудаар мэдээллэж хүнсний зориулатын бус савны хэрэглээ 1.5 хувиар буурсан. | |
| **3.4.НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ** | | | | | | | | | |
| **3.4.1.Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах нөхөн сэргээх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.** | | | | | | | | | |
| 33 | 3.4.1.1. Гадаргын усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулж, усан сан бүхий газрыг нөхөн сэргээх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. | БОГ 2025-2028 | 2,120.00 | Ойжуулсан талбайн хэмжээ 20 га Хөв цөөрөм байгуулсан тоо 2 | 5га 2 | 250.00 | - | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | - |
| 34 | 3.4.1.2. Төв суурин газрын ундны усны нөөцийн судалгааг хийлгэж, усны чанар, аюулгүй байдлыг хангана. | БОГ 2025-2028 | 109.00 Орон нутгийн төсөв | - | Аймгийн хэмжээнд ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ | 33.00 | - | Ундны усны нөөцийн судалгааг "Усны барилга" ХХК-аар хийлгэж нөөцөө тогтоолгосон. Ундны усны усны чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулан Сумыг иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэж байна. | 30 |
| 35 | 3.4.1.3. Усны хэрэглээ, ашиглалтын хэмнэлтийг бий болгож, дахин ашиглалтыг дэмжинэ. | БОГ 2025-2028 | Орон нутгийн төсөв, хувийн хэвшил | Тоолууржуулсан ААН-ийн тоо | 10-аас доошгүй | - | - | Суманд дулааны үйл ажиллагаа эрхэлдэг "Илч касандра" ХХК-ны усны хэрэглээнд тоолуур тавих шаардлагыг хүргүүлж, хэрэгжүүлсэн. | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | 3.4.1.4. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. | БОГ 2025-2028 | 5,426.00 Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр | Шинэ Хархорум хотын төлөвлөлтийн дагуу тарьсан модны тоо Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ 216 га | 1541 га талбайд 850 мянган мод тарина 230 га | - | 9.2 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, хаврын мод тарих өдрийн хүрээнд мод тарих өдрүүдийг зохион байгуулж 37 өрх 230 хайлаас, бургас чацаргана, монос, голт бор, улиас, нохойн хошуу, Засаг даргын Тамгын газар 40 гүйлс, Ерөнхий боловсролын сургууль 450 хайлаас, 360 ширхэг бургас , Цэцэрлэг 40 бургас, Эрүүл мэндийн төв 100 хайлаас, соёлын төв 100 хайлаас, Хаан банк 100 хайлаас, голын дагуу 1050 бургас, нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэнд 760 гүйлс, голт бор, монос , гол гудамж дагуу 25 бургас, улиас тус тус тарьсан. Нийт 3255 мод бут тариалж орон нутгийн төсвөөс 9232.2 мян төгрөгийг зарцуулж ногоон байгууламжийн хэмжээ 1га буюу 10 хувиар нэмэгдсэн. | 100 |
| 37 | 3.4.1.6. Олон улсын төсөл хөтөлбөртэй хамтарч мод бут тарих, мод үржүүлгийн газрыг чадавхжуулах болон иргэд олон нийт, өсвөр үеийнхэнд экологийн боловсрол олгоно. | БОГ 2025-2028 | 48.00 Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр | 17 МҮГ-т 5,2 сая тарьц суулгац байна. | 2.00 | - | 0.1 | Дэлхийн амьтан ургамалыг хамгаалах, байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 19 хүүхдэд "Би ч бас байгаль хамгаалагч" өдөрлөгийг зохион байгуулж, хог хаягдлыг ангилан ялгах, байгаль хамгаалахад хүүхэд багачуудын оролцооны талаар мэдээлэл хийж буддаг ном харандаагаар урамшуулсан. Хавар намрын мод тарих өдрүүдээр 50 иргэнд мод бут тариалах талаар зөвлөгөө мэдээлэл өгч, мод үржүүлгийн газрын дуудлага худалдаа зарласан. | 90 |
| 38 | 3.4.1.7. Нэн ховор, ховор амьтдын амьдрах орчныг сайжруулж, хамгаалалтын арга хэмжээ авна. | БОГ 2025-2028 | 305.00 Орон нутгийн төсөв | Арга хэмжээний тоо 21 | 18 | - | 7.1 | Биотехникийн арга хэмжээг авч, Аргалант ууланд нутагшин амьдардаг Аргаль хонинд 295 боодол өвс, 45 шуудай хужир тавьж өгч, 7.1 сая төгрөгийг зарцуулсан. | 100 |
| **3.4.2.Байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулж, ногоон үзэл санаа, дадлыг нэвтрүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмэр оруулна.** | | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 39 | 3.4.2.4. Энгийн болон аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах оновчтой менежментийн тогтолцоог бүрдүүлнэ. | БОГ<br>2025-2028 | 480.0 Орон нутгийн төсөв | Нийт хог хаягдалд ангилан ялгаж, дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь 0.2 | 0.4 | | 0.6 | Сумын хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги төлөвлөгөөг 6 зүйл 23 заалттайгаар боловсруулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Нийтийн их цэвэрлэгээг 2 удаа, хэсэгчилсэн цэвэрлэгээг 2 удаа, Аргуйн голын дагуух 1км газрын хог хаягдлыг 2 удаа цэвэрлэх ажлыг тус тус зохион байгуулж 70тн хог хаягдлыг хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлж, 0.6 сая төгрөгийг зарцуулсан байна. | 90 |
| | **3.4.3.Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.** | | | | | | | | |
| 40 | 3.4.3.4. Монголын нүүдлийн соёл, түүх болон орон нутгийн онцлогт тохирсон эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | АЗДТГ<br>2025-2028 | 840.00 Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Эвент арга хэмжээний тоо 4 | 5 | 2.9 | 2.9 | Нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйн нэг төрөл болох тэмээн сүргийн тоо толгойг өсгөх, хамгаалах, үүлдэр, ашиг шимийн чанарыг сайжруулах, тэмээний уналга эдэлгээнд ашигладаг уламжлалт арга барилыг нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Тэмээний баяр" арга хэмжээг тэмээчид, сумын Соёлын төвтэй хамтран зохион байгуулж, сайхан буурын төрөлд 6, шилмэл ингэний төрөлд 13, богино зайны 200 метрийн уралдаанд 28, ат, тайлаг, торомны төрөлд 55 тэмээ уралдаж, оролцсон. Тэмээчдийн холбоог 17 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, тэмээний уламжлалт хэрэглээ, соёлыг түгээн дэлэрүүлж, 1 контент бүтээж, нийтэд сурталчилан таниулсан. Өвөрхангай аймгийн бүсийн | 90 |
| | | | | | | | | уралдаан, тэмцээн зохион байгуулагдахаар удирдамж, хөтөлбөрийг боловсруулан, тэмээчдийг идэвхжүүлэх ажлыг зохион байгуулж байна. | |
| | **3.5.БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ** | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.5.1.Сумдын инженерийн шугам сүлжээний бие даасан дэд бүтцийг бий болгож, иргэдийн орон нутагт ажиллаж, амьдрах ая тухтай орчинг бүрдүүлнэ.** | | | | | | | | | |
| 41 | 3.5.1.3. Өлзийт, Есөнзүйл, Бүрд, Баян-Өндөр, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан, Тарагт, Төгрөг сумдыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээтэй болгох зураг төслийг гүйцэтгүүлж, ажлыг эхлүүлнэ. | ГХБХБГ<br><br>2025-2028 | 62,780.00 Улсын төсөв | Сумдын инженерийн шугам сүлжээний зургийн даалгаврыг боловсруулсан. | | | | "Тэнхлэг констракшн" ХХК-тай 19.9 сая төгрөгийн гэрээ хийн сумын дулааны шугамын 2,300 метр газрын зураг төслийг хийж гүйцэтгүүлж байна. | 50 |
| 42 | 3.5.1.6. Сумдын дулааны шугам сүлжээг үе шаттайгаар өргөтгөж, гэр хорооллын айл өрхүүдийг холбоно. | АЗДТГ<br><br>2025-2028 | Дулаан шугамд холбогдсон айл өрхийн тоо 2000 | | | - | - | Дулааны шугамд холбогдох байшинтай өрхийн судалгаа, зах зээлийн үнийн судалгаа, зураг төслийг хийж эхэлсэн. | 30 |
| **3.5.3.Ерөнхий төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг хөгжүүлж, орон нутагт ажиллаж, амьдрах тав тухтай орчинг бий болгоно.** | | | | | | | | | |
| 43 | 3.5.3.1 Сумдын төвүүд доторх хатуу хучилттай авто зам, явган болон унадаг дугуйн зам, гэрэлтүүлгийг өргөтгөн, шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, засвар арчлалт, тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийнэ. | АЗДТГ<br><br>2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | Боловсруулсан ТЭЗҮ, зураг төслийн тоо<br><br>Нэмэгдүүлсэн замын урт 78 км | 2<br><br>79.5 км | - | - | Сумын төвд 2,5 км хатуу хучилттай замд ТЭЗҮ хийлгэхэд шаардлагатай 9.0 сая төгрөгийн дэмжлэгийн хүсэлтийг аймгийн Засаг даргад хүргүүдсэн. | 30 |
| 44 | 3.5.3.3. Сумын төвийн эрчим хүчний уналттай газруудад дэд станц, шугам сүлжээг өргөтгөнө. | АЗДТГ<br><br>2025-2028 | 320.00 Улсын төсөв | Зураг төсөв хийгдсэн | Ажлын гүйцэтгэл 80 хувь | 256.00 | - | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | - |
| **3.6.ГАЗРЫН ХАРИЛЦАА** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.6.1.Аймгийн хэмжээнд газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийж, газар олголтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | |
| 45 | 3.6.1.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. | АЗДТГ<br><br>2025-2028 | 700.00 Орон нутгийн төсөв | Ажлын даалгаварыг боловсруулсан. | Ажлын гүйцэтгэл 30 хувь | 210.00 | | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж байгаа “Газар дэлхий” ХХК-тай сумын ажлын хэсэг 2 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг хийж, санал хүргүүлсэн. | 70 |
| 46 | 3.6.1.4. Төв суурин болон улсын чанартай зам дагуух газруудад хэсэгчилсэн төлөвлөлт хийлгэж, иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна. | ГХБХБГ<br><br>2025-2028 | 150.00 Орон нутгийн төсөв | Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй | | - | - | Сумын төв дайран өнгөрөх улсын чанартай авто зам дагуу 22 иргэнд газар өмчлүүлэхээр 2026 оны сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулсан. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | - |
| 47 | 3.6.1.5. Аймаг болон сумын төвүүдэд нийтийн орон сууцны зориулалттай газруудыг орон нутгийн хэрэгцээнд авч, иргэдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцаар хангах төслүүдийг хэрэгжүүлж, гэр хороолол болон хуучин орон сууцнуудыг дахин төлөвлөлтөд оруулна. | ГХБХБГ<br><br>2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | - | - | - | - | Сумын төвд нийтийн орон сууцны зориулалттай 543 $м^2$ 1 газрыг Засаг даргын Тамгын газарт 60 жилээр эзэмшүүлсэн. | 100 |
| **Хэрэгжилтийн дундаж хувь 83.2 хувь** | | | | | | | | | |

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ТУНГАЛАГ

ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Л.МӨНХЖАВХАА

9045379 СБТ 24449 1024030016

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 10 дугаар сарын 31 — Гучин-Ус сум

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага, хэрэгжих хугацаа | Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая,төг) | Төсвийн гүйцэтгэл (сая,төг) | | |
| 1 | 2-3 | 4-5 | 6-7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| **ДӨРӨВ.ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | |
| **4.1.ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ** | | | | | | | | | |
| **4.1.1.Төрийн бүх шатны байгууллага шийдвэр гаргахдаа хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгон, төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дундаж үзүүлэлтийг 80 хувьд хүргэнэ.** | | | | | | | | | |
| 1 | 4.1.1.1. Нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд жендэр, хүний эрхийн мэдрэмжтэй хандах, хүний эрхийн зөрчил гаргахгүй байх хяналтыг өргөжүүлнэ. | АЗДТГ 2025-2028 | 30.00 Орон нутгийн төсөв | Хүний эрхийн төлөв байдлын тайлангийн үнэлгээний хувь 6.08 /2023 он/ | 7 | 5.00 | - | Засаг даргын Тамгын газар нь нийт 18 албан хаагчдын 10 эмэгтэй, 8 эрэгтэй албан хаагч ажиллаж байна. Жендерийн тэгш байдлыг хангасан. | 100 |
| 2 | 4.1.1.3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтыг | АЗДТГ 2025-2028 | 51.00 Орон нутгийн төсөв | 74,2 шударга байдлын үнэлгээ | 76 | 2.00 | - | Сумын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 бүлэг, 11 заалттайгаар боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласнаар авлига, ашиг сонирхолын зөрчил илрээгүй. Худалдан авах ажиллагааны 9 тендерийн үнэлгээний хорооны дарга, гишүүн, нарийн бичгээр ажиллаж байгаа албан хаагчдаас ашиг сонирхлын зөрчилтэй эсэх | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлж, бүх нийтээр авлигатай тэмцэх, шударга бус зүйлийг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг төлөвшүүлэх бодлогыг үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | | | | мэдээгдийг гаргуулан шилэн данс, сумын веб сайтад нийтлэн ил тод байдлыг хангасан. | |
| **4.1.2.Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэн, жендэрийн мэдрэмжтэй нийгмийн орчинг бүрдүүлж, цаашид гарч болох жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулна.** | | | | | | | | | |
| 3 | 4.1.2.1. Хөвгүүд, эрэгтэйчүүдийн эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг сайжруулах замаар чанартай, урт наслалтыг дэмжинэ. | АЗДТГ 2025-2028 | 15.00 Орон нутгийн төсөв | Сургалт, нөлөөл-лийн арга хэмжээ-5 хөвгүүд, эрэгтэйчүүд тоо-100 | 6 130 | | | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Эрүүл дадал-эрч хүчтэй амьдрал" өдөрлөгийг зохион байгуулж, урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөөг 150 иргэнд хүргэсэн. Эрүүл дадлыг хэвшүүлэхээр эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөний зөвлөмж, мэдээллийг цахимаар сурталчилж, давхардсан тоогоор 6,600 үзэлттэй байна. | 70 |
| 4 | 4.1.2.2. Эрэгтэйчүүдийн нас, эрхэлж буй ажил, салбарын онцлог, амьдарч буй байршил зэргийг харгалзан зам тээврийн осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг цахим орчинд тасралтгүй түгээж, иргэд олон нийтийн хандлагыг өөрчлөх арга хэмжээг бүх шатанд зохион байгуулж, хэвшүүлнэ. | АЗДТГ 2025-2028 | 8.00 Орон нутгийн төсөв | Цахим орчинд түгээсэн мэдээ, мэдээлэл 2 Нөлөөллийн арга хэмжээ 3 | 3 4 | | | Зам тээврийн осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, иргэд, тэр дундаа эрэгтэйчүүдийн аюулгүй байдлын талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх зорилгоор цахим мэдээллийн орчинд сурталчилгаа, мэдээ мэдээлэл хүргэж ажиллав. Сумын Цагдаагийн хэсэг, Эрүүл мэндийн төв, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран "Аюулгүй хөдөлгөөн – хариуцлагатай иргэн", "Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлье" зэрэг цахим нөлөөллийн аянуудыг зохион байгуулж, сумын албан ёсны фэйсбүүк хуудас болон бүлгүүдээр 11 мэдээлэл, сэрэмжлүүлэг, видео контент нийтэлж, 321 хандалт авсан. | 70 |
| 5 | 4.1.2.3. Төрийн байгууллагуудад жендэрийн тэнцвэртэй байдлыг хангах үзэл баримтлалыг нэвтрүүлж, иргэдэд жендэрийн | АЗДТГ 2025-2028 | 10.00 Орон нутгийн төсөв | Жендэрийн мэдрэмж-тэй ажлын байрны бодлого хэрэгжүүлж буй | сум 8 байгууллага 17 | | | Сумын жендерийн дэд хороо хийх ажлын төлөвлөгөөний дагуу сумын эмэгтэйчүүд, ганц бие залуучуудын судалгааг гаргасан. Төрийн байгууллагын ажилтнуудад жендэрийн мэдрэмжтэй бодлого, үйлчилгээний талаарх сургалтыг зохион | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдрэмжтэй төрийн үйлчилгээг хүргэнэ. | | | сум 5 байгууллага 12 | | | | байгуулан, судалгаанд суурилсан жендэрийн тэнцвэрийн үзүүлэлтийг гаргах, байгууллагын түвшинд жендэрийн бодлого нэвтрүүлэх чиглэлээр 2 мэдээлэл хүргэж, зөвлөн туслаеан. Төрийн байгууллагын ажилтнуудад зориулсан "Жендэрийн мэдрэмжтэй бодлого, үйлчилгээний үндэс" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 5 байгууллагын 60 гаруй албан хаагч хамрагдсан. Сургалтаар жендэрийн эрх тэгш байдал, жендэрт суурилсан ялгаварлалаас урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд жендэрийн хандлагыг нэвтрүүлэх талаар мэдлэг олгосон. | |
| **4.1.3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоонд тулгуурласан бодлого хэрэгжүүлж, гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөлийг судлан тогтоох арга зүйг шинэчилж, нутаг дэвсгэрийн хэмжээнд ихэвчлэн үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоог үе шаттай бууруулна.** | | | | | | | | | |
| 6 | 4.1.3.1. Гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөлийн судалгааг сум тус бүрээр шинэчлэн хийж, судалгаанд тулгуурласан урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнд хүрэхүйц байдлаар үе шаттай зохион байгуулна. | АЗДТГ ЦГ 2025-2028 | 225.00 Орон нутгийн төсөв | Нийт гэмт хэрэг 695 2024 онд бүртгэгдсэн. | 0.5 хувиар бууруулна | 75.00 | | Гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцөлийн гол хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор Цагдаагийн хэсэг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл хамтран судалгаа явуулж, "гэр бүлийн орчны зөрчил", "архины хэт хэрэглээ", "залуучуудын чөлөөт цагийн дутагдал" зэрэг давтагдах эрсдэлт хүчин зүйлүүдийг илрүүлэв. Судалгаанд тулгуурлан нөлөөллийн аяныг зохион байгуулж, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх 3 удаагийн сургалт, уулзалтад 220 иргэн хамрагдсан. Үйлчилгээний байгууллагуудад хяналтын камер суурилуулах, архи согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээний цагийн хязгаарлалт тогтоох зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. | 90 |
| 7 | 4.1.3.2. Аймаг, сумын төвийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбай, улсын болон орон нутгийн | АЗДТГ ЦГ 2025-2028 | 332.80 Орон нутгийн төсөв | 90 камер суурьлуулсан | 50 камер | - | 19.2 | Хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын чиглэлээр камержуулалтыг Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн 1, 2 дугаар байр, гадаа талбай, дотуур байранд шинээр байрлуулж, хуучин камеруудыг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | чанартай замын хяналтыг сайжруулж, теле-камерын тоог нэмэгдүүлэх, хүчин чадлыг сайжруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | | —— | | | | | засварлах ажлуудыг хийн 3.2 сая төгрөгийг зарцуулсан. Сумын төвийн гудамж хороололд орон нутгийн сангийн 19.2 төгрөгийн санхүүжилтээр 12 камерыг шинээр байрлуулж, хүчин чадлыг нэмэгдүүлж, камержуулсан. | |
| 8 | 4.1.3.4. Архидан согтуурахтай тэмцэх, архины хор хөнөөлийг нийгэмд таниулах төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг дэмжиж ажиллана. | АЗДТГ ЦГ 2025-2028 | 100.00 Улс, орон нутгийн төсөв | 165 хүн эмчлүүлсэн 2024 оны 10 сарын байдлаар | 1 хувиар бууруулна | | 0.5 | Сумын хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх, архины хор хөнөөлийг таниулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, төрийн байгууллагууд болон сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл хамтран 2 удаагийн сургалт, уулзалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан 350 иргэн хамруулсан. Архины хэрэглээнээс үүдэлтэй зөрчил, гэр бүлийн хүчирхийллийн шалтгааныг бууруулах зорилгоор архины хор уршгийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах зорилгоор иргэдэд мэдээлэл, гарын авлага тарааж өгсөн. Сургуулийн сурагчдын дунд "Архи-Үгүй ирээдүй" сэдэвт гар зургийн уралдаан, эссе бичлэгийн тэмцээн зохион байгуулж, хүүхэд, залуучуудын мэдлэг, хандлагыг эерэгээр өөрчлөхөд анхаарч ажиллав. Үүний үр дүнд архи согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээний цагаар үйлдэгддэг зөрчлүүд өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна | 90 |
| **4.2.2.Мэдээллийн технологи, харилцаа холбооны дэд бүтцийг өргөтгөж, цахим шилжилтийг эрчимжүүлнэ.** | | | | | | | | | |
| 9 | 4.2.2.3.Харилцаа холбооны дэд бүтэц, үүрэн холбооны сүлжээг алслагдсан багуудад өргөтгөж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | АЗДТГ ТЦҮХ 2025-2028 | Улсын төсөв, Орон нутгийн төсөв | Шинээр угсарсан үүрэн холбооны антен 184 | 194 | - | - | Гучин 2 дугаар багийн Эрээлжүүт уул, Аргалант 3 дугаар багийн Аргалант ууланд үүрэн холбооны сүлжээний өргөтгөл хийхээр холбогдох газраас хэрэглэгч өрх, хүн амын судалгаа авсан. | 50 |
| 10 | 4.2.2.4.Төрийн байгууллагуудын | АЗДТГ | Улсын төсөв, | Кибер аюулгүй | 24 | | | Нууцын мэдээлэл агуулж буй компьютер, техник хэрэгсэлд 16 оронгоос доошгүй нууцлалын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, кибер аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийлгэж, зөрчлийг арилгуулна. | ТЦҮХ 2025-2028 | Орон нутгийн төсөв | байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журамтай нийтийн мэдээлэл хариуцагчийн тоо | | | | кодыг хийж хамгаалан 4 багийн Засаг дарга нарын компьютер, ХАӨМС-ийн программ, хувь хүний мэдээлэлтэй эксэл файлыг нууц үг, мэдээллийг шинэчилж, 9 албан хаагчаар нууцын баталгааг гаргуулан холбогдох газарт хүргүүлэн мэдээллийн аюулгүй байдлыг хангасан. | |
| **4.2.3.Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын ил тод байдлын түвшин, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | |
| 11 | 4.2.3.1. Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно. | АЗДТГ 2025-2028 | Улсын төсөв, Орон нутгийн төсөв | Цахим ил тод байдлын индекс<br>74.6<br>Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ<br>94 | 76<br>97 | - | - | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 5 төрлийн 68 мэдээллийг шинэчлэн бүрэн байршуулж, shilen.gov.mn-д 1, 2, 3 дугаар улирлын тайланг бүрэн оруулан, төсвийн 6 байгууллага, төрийн сангийн төсвийн мэдээллийг шилэн дансад 100 хувь байршуулан, цаг үеийн мэдээ, мэдээллийг Засаг даргын Тамгын газрын пэйж хуудас, manage.gov.mn, веб хуудаст нийтэлж мэдээллийг ил тод байдал болон мэдээллийн чанарыг 50 хувиар сайжруулсан. Байгууллагын хэмжээнд хөтлөгдөн гарч буй захирамжлалын болон мэдээлэл лавлагааны баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулан дээд шатны байгууллагаас ирсэн хариутай бичгийн хариуг заасан хугацанд холбогдох газарт хүргүүлж хэвшсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | 4.2.3.2. Төрийн байгууллага албан тушаалтанд хандаж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэх процессыг хялбаршуулж, шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, тухайн байгууллага, албан тушаалтны ажлын үр дүнг тооцдог болно. | АЗДТГ<br>2025-2028 | Орон нутгийн төсөв | Шийдвэрийн хэрэгжилийн хувь<br>Дүн шинжилгээ хийсэн тоо-0 | 97<br>Хувь<br>2 | - | - | Сумын хэмжээнд 3 дугаар улирлын байдлаар нийт 25 өргөдлийг 100 хувь шийдвэрлэж, шийдвэрлэлтийн мэдээг улирал бүр нэгтгэн аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлж хэвшсэн. | 100 |
| **4.2.4.Орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | |
| 13 | 4.2.4.1. Есөнзүйл, Богд сумдын Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барьж, Баянгол, Төгрөг, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Богд, Нарийнтээл, Уянга, Хужирт, Хархорин, Зүүнбаян-Улаан, Бүрд, Өлзийт, Сант сумдын Засаг даргын Тамгын газрын барилгын урсгал засварын ажлыг гүйцэтгэнэ. | АЗДТГ<br>2025-2028 | **6,500.00**<br>Улсын төсөв, Орон нутгийн төсөв | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь-0 | 10 хувь | 60.0 | 59.8 | Засаг даргын Тамгын газрын дотор засварын ажилд 60.0 сая төгрөгийг төсөвлөн, тендер зарлаж 59.8 сая төгрөгөөр "Зодог хайрхан" ХХК шалгарч засварын ажлыг хийж гүйцэтгэж, ажилтан, албан хаагчдын ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлсэн. | 100 |
| 14 | 4.2.4.2. Баг, хорооны үйл ажиллагааны зардлын нормативыг шинэчлэн, сумын төсөвт тусгайлан баталж, сум, багийн Засаг дарга нарыг унаагаар хангаж, төрийн байгууллагуудын техник | АЗДТГ<br>2025-2028 | **836.80**<br>Улсын төсөв, Орон нутгийн төсөв | Мотоциклийн тоо<br>Автомашины тоо<br>14 | 95<br>3<br>57 | 153.1 | 164.7 | Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 06/01 дугаар тогтоолоор багийн Засаг даргын үйл ажиллагаанй зардалд 153,090.9 мянган төгрөгийн төсвийг баталж, аймгийн Засаг даргын А/596 дугаар захирамжаар багийн Засаг дарга нарт 11,640.0 мянган төгрөгийн king 150 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгслийг үе шаттайгаар шинэчилнэ. | | | Компьютерийн тоо | | | | мотоциклийг балансаас балансад шилжүүлэн авсан. | |
| **4.2.5.Төрийн байгууллагаас гарч буй бодлого шийдвэрийн төлөвлөлт, хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлнэ.** | | | | | | | | | |
| 15 | 4.2.5.2. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын дотоод хяналт, шалгалтын нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний орон нутгийн чадавхыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | АЗДТГ<br>2025-2028 | Орон нутгийн төсөв | Өгсөн зөвлөмжийн тоо (хамрагдсан байгууллагын тоогоор)<br>Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо | 5<br>1 | | | Төрийн байгууллагууд дотоод хяналтын нэгжээ шинэчлэн байгуулж, албан хаагчдын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж, ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг 70 хүртэлх оноогоор, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлтийг 15 хүртэлх оноогоор, харилцаа, ёс зүй, ур чадварын байгууллагын даргын үнэлгээ 7 хүртэлх оноогоор, хамт олны үнэлгээг 8 хүртэлх оноогоор тус тус дүгнэж нийт гүйцэтгэлийн 86.34-96.55 хүртэлх хувиар үнэлж үр дүнгийн урамшууллыг 60 хүртэлх хувиар олгосон. Сумын Засаг даргын захирамжаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг томилон төрийн байгууллагуудын 2025 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, зөвлөмж хүргүүлсэн. | 100 |
| 16 | 4.2.5.3.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад хувийн хэвшил, иргэний оролцоот хяналтыг хэрэгжүүлнэ. | АЗДТГ<br>2025-2028 | 36.00<br>Орон нутгийн төсөв | | Иргэдээс ирүүлсэн санал, санаачлага дээр дээр тулгуурласан төрийн үйлчилгээний ахиц, нэр төрөл нэмэгдсэн байдал | | | Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2 удаа төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 103 иргэд, төрийн албан хаагчдыг хамруулан "ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хийж гүйцэтгэсэн ажил, малын тоо толгойн албан татвараар 2021-2024 онд хийж гүйэтгэсэн ажлын төсвийн зарцуулалтад хийх хяналтын сонсголд ажиглагчаар 33, оролцогчоор 70 иргэн оролцож, иргэдийн оролцоо 25 хувиар нэмэгдсэн. | 90 |
| **4.3.ОРОН НУТГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ** | | | | | | | | | |
| **4.3.1.Хүний нөөцийн бодлогыг чадахуйн зарчимд нийцүүлэн хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 17 | 4.3.1.2. Төрийн үйлчилгээний | АЗДТГ | Улс, орон | Нээлттэй сонгон | | - | - | Төрийн үйлчилгээний байгууллагын дарга, багш, нярав, үйлчлэгч, сувилагчийн 12 ажлын байрны сул орон тооны сонгон шалгаруулалтыг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог олон нийтэд мэдээлж, нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулж хэвшүүлнэ. | төрийн байгууллагуу 2025-2028 | нутгийн төсөв | шалгаруулалтын тоо | | | нийтэд ил тод нээлттэй зарлаж, томилгоог хуулийн дагуу хийн хүний нөөцийг бүрдүүлсэн. Томилоготой холбоотой гомдол, маргаан гараагүй. | |
| 18 | 4.3.1.3. Төрийн албаны ерөнхий шалгалтын явц, үйл ажиллагааг олон нийтийн сувгаар шууд дамжуулалт хийж, нээлттэй ил тод болгоно. | АЗДТГ Төрийн байгууллагууд 2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | шалгалтын зохион байгуулалттай холбоотой гомдлын тоо | | - | - | Нийгмийн бодлогын мэргэжилтэн, бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Эрүүл мэндийн даргын сул орон тооны мэдээллийг аймгийн салбар зөвлөлд хүргүүлэн хүний нөөцийн системд албан тушаалын тодорхойлолтыг бүрэн шивж, төрийн албаны болон салбар зөвлөлөөр батлуулан https://www.csc.gov.mn/-д системд сул орон тооны захиалгыг үүсгэн салбар зөвлөлд илгээж, төрийн албаны ерөнхий, тусгай шалгалтад тэнцсэн 1 иргэнийг нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнээр томилсон. | 100 |
| **4.3.2.Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж, төрийн албан хаагчдын мэдлэг мэргэшлийг дээшлүүлж, чадавхыг бэхжүүлнэ.** | | | | | | | | |
| 19 | 4.3.2.1.“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | АЗДТГ 2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | Хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллагын тооны нийт төрийн байгууллагы тоонд эзлэх хувь | 100 | - | 291.0 | Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 11 албан хаагч, удирдах ажилтан 12 дахь жилийн үндсэн сургалт, 2 багш 5 жилийн үндсэн сургалтад тус тус хамрагдаж батламж авч, ажлын байран дээрх 15 удаагийн сургалтад давхардсан тоогоор 278 багш ажилтан, орон нутаг төрөлжсөн 4 төрлийн сургалтад 6 багш, ажилтан хамрагдсан. Мөн мэргэжлийн бусад байгууллагын 115 төрлийн цахим болон танхимын сургалтад 86 ажилтан, албан хаагч хамрагдаж мэдлэгээ дээшлүүлж, 64 албан хаагчийн сургалтын болон томилолтын зардалд 23.7 сая төгрөгийг зарцуулсан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Албан хаагчдын амьдрах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд төрийн албан хаагчдын 12 айлын орон сууц барих 1.3 тэрбум төгрөгийн тендер, биеийн тамирын гадаа талбайн засварыг 80 сая төгрөгөөр, Засаг даргын Тамгын газрын дотор засварын 60.0 сая төгрөгийн тендерүүдийг зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан ажлууд хийгдэж, ажилтан, албан хаагчдын ажиллах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулсан.<br><br>Физикийн кабинетад 1,5 сая төгрөгийн туршилтын багаж хэрэгслийг шинээр авч багшид туршилттай хичээл зохион байгуулах боломжийг бүрдүүлэн 6.0 сая төгрөгийн төгсөгчдийн хандиваар 2 ангийн ширээ сандал шинэчилж, дотуур байрын дотоод тохижилтот 3.0 сая төгрөгийн засварыг хийж орчин сайжруулсан.<br><br>Ур чадварын урамшууллыг багш, удирдах ажилтанд 17.1 сая төгрөг, ажилтан 5.4 сая төгрөг, гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн урамшуулал 14 багшид 32.3 сая, ажлын гүйцэтгэлээр 17 ажилтанд 22.4 сая төгрөг, ҮЭ-ээс хаврын витаминжуулалт, тамирчдын өмсгөлд 2.3 сая төгрөг зарцуулсан байна. Төрийн албан хаагчдын гүйцэтгэтгэл үр дүнг хагас бүтэн жилээр үнэлэн 57 албан хаагчид 60.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, хоолны мөнгийг төрийн 3 байгууллага хоногийн 1,000-2,000 төгрөгөөр бодон олгож, томилолтын зардалд 15.0, бензин түлшид 4.6 сая төгрөгийг тус тус зарцуулан ажилчдын нийгмийн баталгааг хангасан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Ерөнхий боловсролын сургууд багш ажилчдад ажилчдын ажлын хувцас, биеийн тамирын хувцас дэмжлэг үзүүлж, айгууллагын хуримтлалаас 990.000 төгрөг, байгууллагын ҮЭ-ээс 1.340.000 төгрөгийг өгсөн. Эрүүл мэндийн төвийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд албан хаагчдаа бүрэн хамруулж, витаминжуулалтад 2.5 сая төгрөгийн зарцуулан албан хаагчдыг эрүүл мэндийг дэмжин ажилласан. | |
| 20 | 4.3.2.3. Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг бодитой үнэлж, "маш сайн" үнэлэгдсэн төрийн захиргааны албан хаагчдад байгууллагын зүгээс сургалтын төлбөрийн хөнгөлөлт дэмжлэг үзүүлэн төрийн албаны сургалтын байгууллага болох Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулна. | АЗДТГ 2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | сургалтын төлбөрийн хөнгөлөлт дэмжлэг үзүүлсэн тоо мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | | - | - | Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг бодитой үнэлж, "маш сайн" үнэлэгдсэн төрийн захиргааны нэг албан хаагчийг удирдлагын академийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамруулахаар мэдээллийг хүргүүлсэн. | 50 |
| 21 | 4.3.2.4 Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг бодит болгож, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна. | АЗДТГ 2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшний үнэлгээг үнэлсэн | | | | Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны "Аргачлал, загвар батлах тухай" 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын дагуу байгууллын үнэлгээний багийг томилон, ажилтан, албан хаагчдын | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | | | | гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг 70 хүртэлх оноогоор, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлтийг 15 хүртэлх оноогоор, харилцаа, ёс зүй. Ур чадварын байгууллагын даргын үнэлгээ 7 хүртэлх оноогоор, хамт олны үнэлгээг 8 хүртэлх оноогоор тус тус дүгнэж нийт гүйцэтгэлийн 86.34-95.0 хүртэлх хувиар үнэлж үр дүнгийн урамшууллыг 50 хүртэлх хувиар олгосноор ажлын гүйцэтгэл, үр дүн сайжирсан. | |
| 22 | 4.3.2.5. Сумдад төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлөөр төрийн албан хаагчдад зориулсан орон сууц барина. | АСЗДТГ 2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны тоо | | 1,300.0 | - | Төр, хувийн хэвшлийн түншлэлээр суманд 1.3 тэрбум төгрөгийн төрийн албан хаагчийн орон сууц барих ажлыг эхлүүлсэн. | 30 |
| **4.3.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг бууруулна.** | | | | | | | | | |
| 23 | 4.3.3.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг мөрдөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | АЗДТГ 2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | Ёс зүйн зөрчлийн үзүүлэлтийг бууралсан байдал, хувиар 56/тоо/ | 30 | 2.5 | 1.2 | Өвөрхангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн ажлын хэсэгтэй хамтран сумын төрийн албан хаагчдад "Ёс зүйтэй манлайлал" сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, төрийн байгууллагын Ёс зүйн дэд хороод "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль"-аар ажилтан албан хаагчид болон шинээр ажилд орж байгаа албан хаагчдад нийт 24 удаагийн сургалтыг хийн ёс зүйн хариуцлагын гэрээг байгуулан, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх байдлаар ганцаарчилсан уулзалт 17 хийж ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгосон. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | 4.3.3.2.Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэж, хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно. | АЗДТГ Төрийн байгууллагууд 2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | Сургалтад хамрагдсан байгууллагын эзлэх хувь-20 | 40 | | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр", Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" батлагдсантай холбогдуулан байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн ажилтнуудаар хэлэлцүүлэн баталж, ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд хариуцлагын арга хэмжээ тооцохоор оруулж, 2 багшид нээлттэй сануулах арга хэмжээ авч, ёс зүйн зөрчлийг арилгасан. | 100 |
| 25 | 4.3.3.3. Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог чадавхжуулах, ёс зүйн дэд хорооны ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан тогтвортой ажиллах хөшүүрэг болох урамшууллыг олгоно. | АЗДТГ Төрийн байгууллагууд 2025-2028 | Улс, орон нутгийн төсөв | Төрийн бүх шатны байгууллагууд ёс зүйн дэд хороог байгуулсан байна. (Хувиар) 61.9 | 72 | 2.3 | 1.0 | Ёс зүйн дэд хороог чадавхжуулах, ёс зүйн дэд хорооны ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан Ерөнхий боловсролын сургуулийн ёс зүйн дэд хорооны нарийн бичигт урамшууллыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиар сар бүр олгосон. | 30 |
| **4.4.ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТ** | | | | | | | | | |
| **4.4.1.Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудын цэрэг-эх оронч үзлийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | |
| 26 | 4.4.1.1. Дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бэлэн байдлыг хангаж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээг | | | | | | | Сумын дайчилгааны төлөвлөгөөний төслийг 2023 оны статистик мэдээлэлтэй уялдуулан боловсруулж байна. | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | тогтмолжуулан, иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлэх замаар Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх бодлогыг орон нутагт түгээн дэлгэрүүлнэ. | | | | | | | | |
| 27 | 4.4.1.5.Төр, Улаан загалмайн хамтын ажиллагааны нэгдмэл байдлыг зохион байгуулж, төрийн хүмүүнлэгийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлнэ. | 2025-2028 | Орон нутгийн төсөв | | | | | Сумын ИТХ-аас Улаан загалмайн анхан шатны хороог хариуцан Өвөрхангай аймгийн улаан загалмайн хороогоор дамжуулж халамжийн газрын зарласан бүл дэмжих төсөлд сумын өрх толгойлон 2 иргэнийг хамруулаад байна.Уг төсөлд хамрагдсанаар иргэд 1500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламжийг авахаар болж байгаа юм.Мөн 2024 оны эцсээр Гучин-Ус сум улаан загалмайн дансанд татвар хураамжаа бүрэн төвлөрүүлсэн. Өвөрхангай аймгийн Улаан загалмайн хорооны зохион байгуулсан сургалтад 2025 онд хурлын мэргэжилтэн 1 удаа хамрагдсан.Сургалтад өгсөн заавар чиглэлийн дагуу сум орон нутагтаа хүмүүнлэгийн үйл ажиллааг тогтмолжуулж байна. | 100 |
| **Хэрэгжилтийн дундаж 84 хувь** | | | | | | | | | |

**Хэрэгжилт 89.1 хувь буюу "Үр дүнтэй"**

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ТУНГАЛАГ

ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Л.МӨНХЖАВХАА